



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 139

Улаанбаатар хот

Төрийн өмчит хуулийн этгээдийн бусдаас түрээслэх
байр талбайн талаар авах арга
хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчит хуулийн этгээд (төсөвт байгууллага бол батлагдсан төсөвт багтаан)-ийн бусдаас түрээслэх 1 м.кв талбайн 1 сарын түрээсийн төлбөрийн дээд хязгаарыг Нийслэлийн төвийн 6 дүүрэгт 50,000.00 (тавин мянга) төгрөгөөр тогтоосугай.

2.Төрийн өмчит хуулийн этгээд (төсөвт байгууллага бол батлагдсан төсөвт багтаан)-ийн бусдаас түрээслэх 1 м.кв талбайн 1 сарын түрээсийн төлбөрийн дээд хязгаарыг аймаг болон нийслэлийн алслагдсан дүүрэгт 30,000.00 (гучин мянга) төгрөгөөр тогтоосугай.

3.Төрийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал нарт даалгасугай:

3.1.Бусдаас байр талбай түрээслэх бол Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл авч байх;

3.2.Түрээсийн үйлчилгээний гүйцэтгэгчийг холбогдох хууль тогтоомжийн дагуу нээлттэй сонгон шалгаруулах;

3.3.Түрээсийн болон ашиглалтын төлбөр, зардлыг холбогдох төсөв, төлөвлөгөөнд тусгасан байх;

3.4.Түрээсийн гэрээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд байгуулж байх;

4.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан 2018 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 01 дүгээр тэмдэглэлийг хүчингүйд тооцож, энэ шийдвэрийг нийтэд нээлттэй мэдээлэх, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132061279
9-r huraldaan.docx